



УЛААНБААТАР ХОТЫН ШУУРХАЙ УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ТӨВ ОНӨААТҮГ  
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 09 сарын 19 өдөр

Дугаар А/18.

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16.5.2 дахь заалт, “Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төв” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийн 4 дүгээр хэсгийн 4.9.9 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Дуудлага бүртгэлийн програм худалдан авах гэрээ” 17/32-21, “Discenter програм хангамжийн өргөтгөл, сайжруулалтын ажил хийж гүйцэтгэх гэрээ” 17/33-28, “Багаж хэрэгсэл, сэлбэгийн нөөц нийлүүлэх ажлын гэрээ” 17/34-02 тоот гэрээт ажлын явцын гүйцэтгэлийг хянаж, баталгаажуулах, ашиглалтад хүлээн авах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар байгуулсугай.

2. Гүйцэтгэгчийн шинээр суурилуулсан тоног төхөөрөмжийн чанар, үзүүлэлт нь гэрээнд заасан нөхцөлийг хангасан эсэхийг нягтлан шалгаж, гүйцэтгэлийг баталгаажуулахыг Ажлын хэсэг /Б.Дамдинжав/-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт, хамтын ажиллагаа хариуцсан Ахлах мэргэжилтэн /Н.Батсүх/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ГАН-ОЧИР

УБ хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын  
төвийн даргын 2017 оны 09 дүгээр сарын 19 ний  
өдрийн 47 дугаар тушаалын хавсралт



### Гэрээт ажлыг хүлээн авах Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн

ахлагч:	Б.Дамдинжав	Улаанбаатар хотын удирдлага, зохицуулалтын Ерөнхий диспетчер	Шуурхай төвийн
Гишүүд:	Г.Билгүүн	Улаанбаатар хотын удирдлага, зохицуулалтын Техник хангамжийн инженер	Шуурхай төвийн
	Э.Мэндбаатар	Улаанбаатар хотын удирдлага, зохицуулалтын Сүлжээний инженер	Шуурхай төвийн
	Д.Одончимэг	Улаанбаатар хотын удирдлага, зохицуулалтын Нярав	Шуурхай төвийн
Нарийн бичгийн дарга:	П.Батбилэг	Улаанбаатар хотын удирдлага, зохицуулалтын Системийн ахлах инженер	Шуурхай төвийн